



ОРШИЛ

2010 он Сүрьеэтэй тэмцэх түншлэлийн байгууллагын (Stop TB Partnership) 2006–2015 онд Сүрьеэгийн тархалтыг бууруулах Дэлхийн нийтийн зорилт (Global Plan to Stop TB) дэвшүүлснээс хойш эхний хагас хугацааны нь өнгөрсөн байна. Цаашид үлдсэн хагасад бид хүчин зүтгэл, чармайлтаа нэмэгдүүлж, тавьсан зорилтдоо хүрэх шинэ арга зам эрэлхийлэх, шинэ шинэ үйл ажиллагааг эхлүүлэх хэрэгтэй байгаа нь улам тодорхой болж байна.

Өнгөрсөн хугацаанд бид олон зүйлийг бүтээжээ. Гэхдээ нэн даруй, илүү оновчтой шинэчлэлийг илүү их хурдтайгаар хийх шаардлагатай байгааг бодит байдал харуулж байна.



ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Урьдчилан сэргийлэлт, оношлогоо, эмчилгээний шинэ арга нэвтрүүлэх

Өнгөрсөн жилүүдэд сүрьеэтэй тэмцэх ажлын хүрээнд эрдэм шинжилгээ, судалгааны олон ажлууд хийгдэж багагүй амжилт олсон боловч цаашид илүү сайн оношлогоо, эмчилгээний арга аргачал бий болгох, судалгаа хийхэд илүү их хөрөнгө шаардлагатай байна. Түүнчлэн сүрьеэгийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах, эмэнд дасалтай сүрьеэгээс сэргийлэхэд ч нэмэлт санхүүжилт хэрэгтэй байна.

Дэлхийн нийтийн зорилтод 2010 онд сүрьеэгийн эрдэм шинжилгээ, судалгааны ажилд 1.1 тэрбум ам.доллар хэрэгтэй болохыг заасан боловч энэ ажилд 0,6 тэрбум ам доллар дутагдаж байна. Сүрьеэ өвчний чиглэлээр хийгдэх судалгаа шинжилгээний ажилд хүлээх боломж бага, дэлхийд сүрьеэгийн тхиолдол нэмэгдэхэд олон хүчин зүйл нөлөөлж, уг өвчний улмаас жил бүр 2 сая шахам хүн нас барж байна.

Сүрьеэгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх

Бид олон олон үйл ажиллагааг хэрэгжүүлсний үр дүнд 2004 оноос хойш сүрьеэгийн өвчлөл, нас баралт буурч байгаа боловч дэлхийн хэмжээнд сүрьеэтэй өвчтөний 3-ны нэг хувь нь тусламж үйлчилгээ, зөв оношлогоо, үр дүнтэй эмчилгээ авч чадахгүй байна. Сүрьеэтэй өвчтний тусламж үйлчилгээний тунхаг бичигт “сүрьеэтэй өвчтөн



бүр хөрөнгө мөнгө, арьсны өнгө, нас хүйс, хэл, эрх зүйн байдал шашин шүтлэг, бэлгийн чиг хандлага, соёл, бусад өвчин эмгэгээс үл хамааран онош тавьснаас эхлэн эмчилгээгээ хийлгэж дуусах хүртлэх хугацаанд сүрьеэгийн тусламж үйлчилгээг үнэгүй, эрх тэгш авах эрхтэй” гэж заасан байдаг.

Шинэ технологи нэвтрүүлэх ажлыг дэмжих

Одоогийн байдлаар сүрьеэг оношлоход нэгэнт нээгдсэн хурдавчилсан аргуудыг хэрэглэх, цаашид өөр шинэ боломжтой аргуудыг нэвтрүүлэх. Үйлдвэрлэгчид, санхүүжүүлэгчид, зохионбүтээгчдэд хамтран ажиллаж тусламж үйлчилгээний шинэ арга аргачлалыг аль болох яаралтай бий болгох шаардлага тулгарч байна.

Хамтын ажиллагааг улам тогтвортой болгох

Сүрьеэгийн тархалтыг бууруулах Дэлхийн нийтийн зорилтыг 2006–2015 онд дэвшүүлснээс хойшхи 5 дахь жил нь 2010 он болж байна. Хамтран ажиллаж шинэчлэл хийж байж дэвшүүлсэн зорилтоо биелүүлнэ гэж үзэж байна.

Хөрөнгө бүрдүүлэх шинэ арга зам олох

Дэлхийн нийтийн зорилтод заагдсан 2010 оны үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд 2,4 тэрбум ам.доллар, 2011–2016 онд хийгдэх үйл ажиллагаанд урьдчилсан байдлаар 23,8 тэрбум ам.доллар шаардагдлагатай гэсэн тооцоо гарч байна. Зорилтондоо хүрэхийн тулд бүсийн, үндэсний, орон нутгийн бүхий л түвшинд хөрөнгө санхүүгийн шинэ эх сурвалж бий болгох хэрэгтэй байна.



2010 оны аян - шинийг санаачлагчиг

Энэ жилийн сүрьеэтэй тэмцэх өдрийн аян нь сүрьеэгийн тусламж үйлчилгээнд шинэ арга аргачлал нэвтрүүлж байгаа хүмүүст чиглэх ба тэднийг хийж буй ажлаа бусдад хүргэхийг уриалж байна.

Доорхи чиглэлээр хийгдэж буй судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг сайшаан дэмжих

- Оношлогооны шинэ арга, эм, вакциныг бий болгох
- Сүрьеэгийн тусламж үйлчилгээг илүү үр дүнтэй, хүртээмжтэй болгох
- Сүрьеэгийн оношлогоо, эмчилгээг хүмүүст ойртуулах
- Хамтын ажиллагааг өргөжүүлэх
- Эрүүл мэндийн байгууллагуудыг сүрьеэтэй өвчтөний тусламж үйлчилгээнд татан оролцуулах
- Сүрьеэтэй өвчтөнд хамт олны зүгээс үзүүлэх дэмжлэгийн шинэ хандлага бий болгох
- Сүрьеэ өвчинд хандах хандлагыг дээшлүүлэхэд чиглэсэн шинэчлэл хийх

Аяны ажлын агуулга

- Байгууллага, хамт олны дунд сүрьеэгийн үйл ажиллагаанд шинэ санаа санаачлага гаргаж буй хүмүүсийг дэмжих, урамшуулах
- Самбар, зурагт хуудсаар дамжуулан шинэ санаачлагчдыг сурталчлах
- Төвийн болон орон нутгийн хэвлэл мэдээллээр ололт амжилтын тухай мэдээлэл түгээх



Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдрийн төлөвлөгөө

Сүрьеэтэй тэмцэх өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхийн учир нь сүрьеэтэй тэмцэх ажилд нийгмийн ба засгийн газрын оролцоог нэмэгдүүлэхэд оршино. Бүтэн жилийн хугацаанд үргэлжлэх энэ ажил нь үндэсний, бүсийн хэмжээнд мөн түүнчлэн танай улс оронд сүрьеэгийн өвчлөл ямар байгаа тухай нийгмийн бүх л давхрагад мэдээлэх, тэдний ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх завшаан олгож байна.

Сүрьеэтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, иргэний нийгмийн төлөөлөл, сүрьеэд өртөмтгий бүлэг зэрэг бүх л хамтран ажиллагчид сүрьеэтэй тэмцэх өдрийн үйл ажиллагаанд хамтран оролцоно гэдэгт итгэж байна.

Сүрьеэгийн тусламж үйлчилгээнд шинэчлэл хийцгээе гэсэн энэ жилийн уриа нь та бүхний сүрьеэг оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх ажилд нэвтрүүлж буй шинэ арга барил, олж буй ололт амжилтаа бусдадаа тайлагнах боломж олгож байна.

Сүрьеэтэй тэмцэх түншлэлийн байгууллагын (Stop TB Partnership) дэвшүүлсэн сурталчилгаа, ухуулга нөлөөлийн ажлын аргачлал нь Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдрийн үйл ажиллагааг амжилттай зохион байгуулахад та бүхэнд туслах болно.

Сурталчилгаа ухуулга, нөлөөлөлийн зорилго нь:

- Бодлого боловсруулагч нарт чиглэсэн ажлыг эрчимжүүлснээр сүрьеэтэй тэмцэх ажилд тэдний оролцоог нэмэгдүүлэх



- Зорилтот бүлгийн хүмүүсийн мэдлэг, хандлага дадлыг өөрчлөх
- Олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд оршино

Сурталчилгаа, ухуулга нөлөөлийг тасралтгүй хийснээр:

- хөтөлбөрийн хүрээнд олсон амжилтаа бататгах
- шийдвэр гаргагч нарын зүгээс дэмжлэг, санхүүжилт нэмэгдэнэ,
- шинэ хамтрагч олж тэдний ажлыг сүрьеэтэй тэмцэх ажилд чиглүүлнэ,
- сүрьеэгийн оношлогоо, эмчилгээний хэрэгцээ нэмэгдэнэ
- олон нийтийн дундах сүрьеэгийн тухай эерэг ойлголтыг нэмэгдүүлэх, улс төр нийгмийн зүтгэлтнүүдийг сүрьеэтэй тэмцэх үйл ажиллагаанд татан оролцуулах үүний тулд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллах ач холбогдолтой



Төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх

Сүрьеэтэй тэмцэх өдрийг зохион байгуулах хорооны зөвлөмж болгож байгаагаар энэ үйл ажиллагаанд доорхи байгууллага, бүлэг, хувь хүмүүсийг заавал татан оролцуулах шаардлагатай. Үүнд:

- СТҮХөтөлбөр болон орон нутгийн сүрьеэгийн байгууллагын эмч, эрүүл мэндийн ажилтнууд
- Төрийн бус байгууллагууд
- Эмч, эрүүл мэндийн ажилчдын холбоо
- Оюутны, шашны болон эмэгтэйчүүдийн байгууллага
- Хэвлэл мэдээллийн байгууллагууд
- Сүрьеэд өртсөн хүмүүсийн нийгэмлэг
- Улс төрчид
- ХДХВ/ДОХ-ын хөтөлбөр
- Сүрьеэтэй тэмцэх өдрийн үйл ажиллагаанд шинээр татан оролцуулах бүлэг хүмүүс

Сүрьеэтэй тэмцэх өдрийг зохион байгуулах хороо нь гарах чиглэлээр ажиллана:

- Бодит шаардлага дээр үндэслэсэн үйл ажиллагааг төлөвлөнө/ямарүйлажиллагаанд хэдэн хүн хамрагдах г.м/
- Сурталчилгаа, ухуулга, нөлөөллийн ажлыг сонирхол татахуйц байдлаар зохион байгуулна
- Үйлдвэрлэл, худалдаа эрхлэгчдэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулж хөрөнгө санхүүгийн дэмжлэг авах
- Үйл ажиллагаа хийх хугацааг тодорхой болгох
- Хийгдэх ажил, хариуцах эзэн, хамруулах хүрээ зэргийг тодорхой заасан хүснэгт гаргах



Мэдээ, мэдээлэл цуглуулах

Ухуулга, нөлөөллийн ажлыг төлөвлөхийн өмнө өөрийн аймаг, дүүргийн сүрьеэгийн хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд үнэлгээ өгч, учирч буй бэрхшээлийг тодорхойлон цаашид авах арга хэмжээг төлөвлөх нь зүйтэй.

Сүрьеэгийн өвчлөлийн тухай гарах мэдээллийг заавал багтаана:

- Сүрьеэгийн өвчлөл, тархалт
- Сүрьеэгийн нас баралт
- Нийт хүн амын өвчлөл ба эрсдэлт бүлгийн өвчлөл
- ДОТС-ын хамралт
- Сүрьеэ/ХДХВ-ийн хавсарсан халдвар, ОЭДС
- Сүрьеэгийн өвчлөлд нөлөөлөх эдийн засгийн хүчин зүйлс
- СТҮХ-д зориулан засгийн газраас /орон нутгийн төсөв/ зарцуулж буй хөрөнгө
- Нийгмийн өртөг – өвчтөний гэр бүлд, нийгэмд болон улс оронд

Доорхи нөхцөл байдлаас хамааран сүрьеэ өвчний тухай мэдээлэл нь өөрийн онцлогтой байна

- Өвчлөлийн байдал
- Хэн хамгийн ихээр сүрьеэд өртөж байна
- ДОТС-ын бодлогын хамралт
- Сүрьеэтэй тэмцэх ажилд зарцуулж буй санхүүжилт
- Бусад улс орнуудад хийгдсэн үйл ажиллагаа
- Идэвхгүй байдлын учир шалтгаан



Тухайн орон нутгийн нөхцөл байдалг тохирсон мэдээлэл

Сүрьеэтэй тэмцэх өдөрт зориулан гаргасан мэдээллээс өөрсдийн нөхцөлд тохирсон гол мэдээллээ сонгоно.

Сүрьеэтэй тэмцэх үйл ажиллагааны явцад олсон амжилт, дутагдалтай талыг харуулах, цаашид хийх ёстой ажлыг төлөвлөснөөр үйл ажиллагаанд бусдыг татан оролцуулна

Боломжтой бүх л сувгаар мэдээ, мэдээллийг дамжуулвал хамгийн сайн үр дүнг авчирч чадна.

Мэдээлэл нь дараах байдлыг хангах ёстой

- зорилгоос хамаарч бүлэг бүрд ялгаатай
- тодорхой
- ойлгомжтой, цөөн үгээр

Жишээ нь:

бид дэвшилт хийж байна – амжилттай хэрэгжүүлсэн үйл ажиллагааг тодорхой хугацаатай заах

сүрьеэтэй тэмцэхэд хүн бүр оролцдог – танай орон нутагт хэн хэн сүрьеэтэй тэмцэх ажилд хамтран оролцдог болохыг тодорхой хэлэх

дэлхий дахинд сүрьеэ өвчин нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал хэвээр байна – өөрийн орон нутагт байгаа бэрхшээлтэй асуудлыг хөндөн тавьж үүнийг шийдвэрлэхэд хэн юу хийх хэрэгтэй байгааг зааж өгнө

нийгэм эдийн засгийн нөлөө – хувь хүний амьдрал, улс орон нутгийн эдийн засагт ямар нөлөө үзүүлж байгааг баримттайгаар үзүүлэх



Сүрьеэтэй тэмцэх өдрийн үйл ажиллагаанд хамтран ажиллагчид, түншлэгчдийг татан оролцуулах

Хүн амын дунд мэдээ, мэдээлийг сонирхолтой байдлаар хүргэх тэдний хүсэл сонирхлыг нэмэгдүүлэхүйц үйл ажиллагааг явуулах нь чухал

Орон нутгийн бизнес эрхлэгчдийг сүрьеэтэй тэмцэх өдрийн үйл ажиллагаанд татан оролцуулах, тэдний дэмжлэгийг авах

Тэдэнд өөрийн сайн дураар энэ ажилд оролцох нь бусдад сайн үлгэр жишээ болохыг, олоннийтийн дунд тэдний нэр хүнд нэмэгдэхийг тайлбарлах нь зүйтэй. Ярилцлага, уулзалт зохион байгуулах, жагсаал, улс төрийн зүтгэлтнүүд оролцсон хэвлэлийн бага хурал хийх, шинээр нээгдсэн эмчилгээ үйлчилгээний төвийн нээлтэд оролцуулах зэргээр тэднийг энэ ажилд татан оролцуулж болно.

Шинэ зүйлийг санаачлах хэрэгтэй: худалдааны төвд рор дуучид оролцсон концерт тоглох, хэвлэл мэдээллийнхэн оролцсон биеийн тамирын тэмцээн зохион байгуулах г.м

Хийж буй үйл ажиллагаанууд нь дараах шалгуурыг хангасан байна:

- бизнес эрхлэгчид гэх мэт түншлэгчдийг оролцуулах
- энэ бүлгийн хүмүүст зориулсан тодорхой мэдээлийг өгөх
- зохион явуулж буй ажлаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн нэвтрүүлэх



Хэвлэл мэдээллийнхэнтэй хамтрах

Илтгэл, тоо баримт мэдээллийн жагсаалт, нэвтрүүлэг бэлдэх

Энэ номонд буйзагварыг ашиглан тоо баримт, үндсэн гол мэдээлэл бүхий сурталчилгааны материал бэлдэнэ. Үүнд олон нийт, хамтран ажиллагчид болон хэвлэл мэдээллийнхэнд зориулсан видео, зурагт самбар, баримт мэдээллийн жагсаалт орно.

Хэвлэл мэдээллийн үйл ажиллагааг зохион байгуулах

- эрүүл мэндийн нэвтрүүлэг хийдэг орон нутгийн болон үндэсний түвшний хэвлэл мэдээллийн байгууллагуудтай холбоо тогтоох
- үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн шинэ ажлуудыг таниулах хэвлэлийн бага хурал зохион байгуулах
- улс төрчид, төрийн бус байгууллагын төлөөллийг хэвлэлийн бага хуралд урьж оролцуулах
- сүрьеэтэй тэмцэх өдрийн хүрээнд зохион байгуулж буй ажлаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах
- өвчлөлийн тухай тоо мэдээ болон үйл ажиллагааны тухай нэвтрүүлэг үзүүлэх
- телевизийн сувгийн нэг өдрийг сүрьеэтэй тэмцэх өдрийн үйл ажиллагаанд зориулах



3-р сарын 24 нөөс хойш юу хийх вэ

Сүрьеэтэй тэмцэх өдрөөр зохион байгуулсан ухуулга нөлөөлийн ажлыг дүгнэх

- үйл ажиллагааг зохион байгуулахад хэдэн хүн оролцсон
- эдгээр хүмүүс ямар үүрэг гүйцэтгэсэн
- ямар шинэ ажлыг зохион байгуулсан
- үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулсан ба амжилттай зохион байгуулсан эсэх
- зорилтот бүлгийн хүмүүсийн ойлголт, хандлагад өөрчлөлт гаргаж чадсан эсэх зэргийг тус тусад нь дүгнэж хэлэлцэнэ

Үнэлгээ өгөх

үнэлгээ өгөх нь цаашид хийх ажлыг сайжруулах төдийгүй үйл ажиллагааг амжилттай хийснээр хамтран ажиллагчдыг цаашид улам илүү татан оролцуулах ач холбогдолтой. Зарим үйл ажиллагааны амжилтыг хэдхэн өдрийн дараа үнэлэх боломжгүй. Үнэлгээ хийх ажлыг зохион байгуулахдаа:

- зорилго, зорилтондоо хүрсэн эсэх
- үйл ажиллагааг үнэлж болох шалгуур үзүүлэлтүүдийг тодорхой болгох (сүрьеэгийн тухай зөв мэдлэгтэй болсон хүний тоо, өвчтөний хожимдлын хугацаа, санхүүжилт нэмэгдсэн байдал г.м)
- хяналт үнэлгээний төлөвлөгөө гаргана
- хяналт, үнэлгээ хийх аргаа сонгоно (тооны ба чанарын)